



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/48.

Хөхбүрд

Байгаль хамгаалах аянд нөөц
хөрөнгөөс хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсны Засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИАРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн усны өдрийг жил бүрийн уламжлалт болгон тэмдэгдлэн өнгөрүүлж гар зургийн уралдааныг зохион байгуулах, бүлэг тус бүрээр байр эзлүүлэх, усны хэрэглээ, зохистой ашиглалт, хамгаалалт, орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах сургалт мэдээлэл, арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах 129.000 (нэг зуун хорин есөн мянган) төгрөгийг, “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон сум” аяны нээлтийн аннос (3x4), мод тарьсан газрын самбар пайз 30 ширхэг, авто стикер (60x40) 30 ширхэг зэрэг ажилд зарцуулагдах 1.189.000 (нэг сая нэг зуун наян ес) төгрөгийг тус тус Засаг даргын дарга (М.Жавзансүрэн), Нягтлан бодогч (Л. Алимаа) нарт зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Г. Ганцоож)-д даалгасугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

642301065